

“Инновэйшн Инвестмент” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын  
2024 оны 05 дугаар сарын 22 ны өдрийн 05/03 тогтоолын  
1 дугаар хавсралтаар батлав



## **“ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ” ХК ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ**

### **Нэг. Ерөнхий зүйл**

- 1.1. Энэхүү “Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам” (цаашид “Журам” гэх)-ын зорилго нь “Инновэйшн Инвестмент” ХК (цаашид “Компани” гэх)-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-ийн гишүүдэд тавигдах шаардлага, гишүүдийн үүрэг хариуцлага, ТУЗ-ийн дарга болон ТУЗ-ийн нарийн бичгийн даргын бүрэн эрх, хариуцлага, ТУЗ-ийн хороодын чиг үүргийг тодорхойлж, ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлэх, шалгаруулах, гишүүдийн үйл ажиллагаанд дүгнэлт өгөх, ТУЗ-ийн хурлыг зарлах, түүнд бэлтгэх, хуралдуулах, ТУЗ дээр шийдвэр гаргах, шийдвэрийг мэдээлэх, биелэлтэд хяналт тавих, ТУЗ-ийн гишүүдийн идэвх санаачилга, үр бүтээлтэй ажиллах нөхцөлийг бүрдүүлэхүйц цалин урамшуулал олгох, хариуцлага хүлээлгэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. ТУЗ-ийн гишүүн (цаашид “Гишүүн” гэх) нь хэлэлцэж буй аливаа асуудалд ажил хэрэгч, үнэнч шударгаар хандан, зохих хууль тогтоомжийн хүрээнд, үнэн зөв мэдээлэлд үндэслэн шийдвэр гаргахад оролцож, шийдвэр гаргахад Компанийн эрх ашгийг дээдлэх зарчмыг баримтлан, хууль болон Компанийн дүрэм, энэ журмаар тогтоосон үүргээ чанд биелүүлж ажиллана.
- 1.3. ТУЗ-ийн гишүүд нь төрийн эрх бүхий байгууллага, улс төрийн нам, албан тусшаалтан, гүйцэтгэх удирдлага болон хувийн ашиг сонирхолын нөлөөнд авталгүй нийт хувьцаа эзэмшигчид, Компанийн эрх ашгийг дээдлэн Компанийн тухай хууль, Компанийн дүрэм, холбогдох бусад хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулж, аливаа асуудлыг шийдвэрлэнэ.
- 1.4. ТУЗ нь шинээр батлагдсан хууль тогтоомж, төрийн байгууллагын тогтоол, шийдвэр, компанийн дүрэмд орсон өөрчлөлт зэрэгт нийцүүлэн энэ журамд зохих нэмэлт, өөрчлөлт оруулж болно.
- 1.5. ТУЗ-ийн хурлаар асуудал шийдвэрлэхэд ТУЗ-ийн гишүүн бүр саналын нэг эрхтэй байна.

### **ХОЁР. ТУЗ, ТҮҮНИЙ ЧИГ ҮҮРЭГ**

- 2.1 Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих байгууллага нь ТУЗ байна.
- 2.2 ТУЗ нь компанийн үйл ажиллагааг байнгын, тогтвортой, мэргэжлийн удирдлагаар хангаж, Компанийн тухай хууль, Төрийн холбогдох эрх бүхий байгууллагаас батлан гаргасан дүрэм журам, бусад хууль тогтоомжийг удирдлага болгон компанийн дүрэмд заасан эрх, үүргийг хэрэгжүүлж ажиллана.



- 2.3 ТУЗ нь 9 гишүүнтэй байна. Компанийн ТУЗ нь Компанийн тухай хууль, компанийн дүрэм болон энэ журмын 3 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан 3 хараат бус гишүүнтэй байна.
- 2.4 ТУЗ нь компанийг зүй зохистой удирдан сайн засаглалын практикийг хэвшүүлж стратегийн удирдлагаар хангах, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаанд хяналт тавих үндсэн үүрэгтэй.
- 2.5 ТУЗ нь Компанийн тухай хууль, Компанийн дүрэмд заасан өөрийн бүрэн эрхийн хүрээнд шийдвэрлэх асуудлаас гадна энэ журмын 2.6-2.11 дэх хэсэгт заасан асуудалд хамаарах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.
- 2.6. Компанийн засаглалын асуудлаар ТУЗ нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:
- 2.6.1. Компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тогтоох, богино, дунд, урт хугацааны бизнес төлөвлөгөөг батлах, хэрэгжүүлэх, түүнд хяналт тавих;
- 2.6.2. Стратегийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх тодорхой үе шатуудыг тогтоох;
- 2.6.3. ТУЗ, түүний дэргэдэх хороод, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны болон компанийн засаглалын дотоод журмыг батлах, хэрэгжилтэнд нь хяналт тавих;
- 2.6.4. Компанийн гүйцэтгэх удирдлагыг томилох, өөрчлөх болон түүний бүрэн эрхийг тогтоох;
- 2.6.5. Компанийн бүтэц зохион байгуулалт, орон тоо, хүний нөөцийн бодлогыг батлах, хэрэгжилтэнд хяналт тавих;
- 2.6.6. Компанийн гүйцэтгэх удирдлагатай байгуулах гэрээний нөхцөл, түүнд олгох шагнал, урамшуулал, хариуцлагын хэмжээг тогтоох;
- 2.6.7. Компанийн салбар болон төлөөлөгчийн газар байгуулах, тэдгээрийн удирдлагыг томилох, гуравдагч компанийн хувьцаа худалдан авах, захиран зарцуулах, хөрөнгө оруулах шийдвэр гаргах, хуульд, дүрэмд заасан бол ХЭХ-д саналаа оруулах;
- 2.6.8. Эрсдлийн удирдлага болон санхүүгийн үйл ажиллагаа, үндсэн үйл ажиллагааны зардалд мониторинг хийх тогтолцоог бүрдүүлэх; үүнд: гадаад, дотоод үйл ажиллагааны бүхий л эрсдэл, санхүү ба хуулийн хэрэгжилт болон бусад эрсдэлийг эрсдэлийн менежментээр хангах нэгдсэн үйл ажиллагааг хариуцна.
- 2.6.9. Компанийн нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлангийн үнэн зөв, бүрэн, бодит байдлыг хангах болон нягтлан бодох бүртгэл, аудитын олон улсын стандартыг нэвтрүүлэх ажиллагаанд хяналт тавих;
- 2.6.10. Компани хууль тогтоомжид зааснаар төрийн эрх бүхий байгууллага, харилцагчид болон олон нийтэд хүргэх тайлан, мэдээллээ цаг хугацаанд нь бүрэн, үнэн зөв хүргэж, нийтэлж байгаад хяналт тавих.
- 2.7. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг бэлтгэн, зохион байгуулах асуудлаар ТУЗ нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:
- 2.7.1. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах;
- 2.7.2. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал, саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийг тодорхойлох, хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулахтай холбогдох бусад асуудлыг шийдвэрлэх;
- 2.7.3. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх, бууруулах талаар санал бэлтгэн хувьцаа эзэмшигчдэд хүргүүлэх, шийдвэрлүүлэх;



- 2.7.4. Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гаргаж, түүнийг хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж батлуулах;
- 2.7.5. Компанийг өөрчлөн байгуулах талаар хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолын төслийг бэлтгэх, гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх;
- 2.7.6. Компанийг татан буулгахтай холбоотой комисс томилох, татан буулгах хугацаа, журам, зээлдүүлэгчдийн нэхэмжлэлийг барагдуулсны дараа компанид үлдэх эд хөрөнгийг хувьцаа эзэмшигчдэд хуваарилах журам зэрэг компани татан буулгах төслийг боловсруулах;
- 2.7.7. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудлыг батлах.
- 2.8. Үнэт цаас болон актив, хөрөнгийн асуудлаар ТУЗ дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:
  - 2.8.1. Компанийн зарласан хувьцааны төрөл болон тоо хэмжээнд багтаан хувьцаа, өрийн бичиг гаргах;
  - 2.8.2. Компанийн гаргасан хувьцаа, бусад үнэт цаасыг худалдан авах буюу эргүүлэн авах компанийн үнэт цаасыг гаргах, үүнд, компанийн бонд гаргах, эсхүл зарласан хувьцааны тоо, төрөлд багтаан хувьцааг гүйлгээнд гаргах шийдвэр гаргах;
  - 2.8.3. Эчнээ санал хураалт явуулах эсэхийг шийдвэрлэх;
  - 2.8.4. Эд хөрөнгийн болон эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг тогтоох;
  - 2.8.5. Шинэ төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, хөрөнгө оруулалт хийх эсэх талаар шийдвэрлэх, Компанийн Гүйцэтгэх удирдлагад чиглэл өгөх;
  - 2.8.6. Компанийн тухай хуулийн 11, 12 дугаар бүлэгт заасан их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй гэрээ хэлцэл хийх зөвшөөрөл олгох;
  - 2.8.7. Ногдол ашиг хуваарилах эсэх, хэмжээ, төлөх журмыг тодорхойлох, энэ тухай тайлан гаргах;
  - 2.8.8. Компанийн жилийн төсвийг хэлэлцэх, батлах.
- 2.9. Гүйцэтгэх удирдлага болон аудитортой харилцах асуудлаар ТУЗ дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:
  - 2.9.1. Компанийн гүйцэтгэх удирдлагатай байгуулах гэрээний нөхцөл, бүрэн эрх олгох шагнал, урамшуулал, хариуцлагын хэмжээг тогтоох;
  - 2.9.2. Гуравдагч этгээдээс богино болон урт хугацаатай зээл авах, бусдад зээл олгох, гуравдагч этгээдээр баталгаа, батлан даалт гаргуулах, бусдын өмнөөс баталгаа, батлан даалт гаргах болон компанийн хөрөнгийг барьцаалах эрхийг Гүйцэтгэх удирдлагад олгох;
  - 2.9.3. Компанийн тухай хуульд заасан их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулах зөвшөөрлийг олгох
  - 2.9.4. Компанийн хөндлөнгийн аудиторыг сонгож, түүнтэй хийх гэрээний нөхцөлийг тогтоох, Хөндлөнгийн аудит, түүнээс үйлчилгээ авахтай холбоотой бодлогыг тодорхойлох;
  - 2.9.5. ТУЗ-ийн даргын санал болгосноор Компанийн дотоод хяналтын ажилтан, даргыг томилох, чөлөөлөх, Дотоод хяналтын журмыг батлах;
  - 2.9.6. Дотоод хяналтын нэгжийн ажлын хөлс, ажиллах нөхцөлийг тодорхойлох;



- 2.9.7. Компанийн нөөцийг (хүний болон санхүүгийн) зүй зохистой ашиглах талаар дэмжлэг үзүүлэх;
  - 2.9.8. Эрх бүхий албан тушаалтны компанид учруулсан хохирлын талаар шүүхэд нэхэмжлэл гаргах;
  - 2.9.9. Тайлагнал, хариуцлага, дотоод сахилга батыг сайжруулах;
  - 2.9.10. Компанийн хувьцаа эзэмшигчид болон удирдлагын хооронд, хувьцаа эзэмшигчдийн хооронд, компани болон бусад оролцогчдын хооронд сонирхлын зөрчил үүссэн тохиолдолд зуучлагчийн үүрэг гүйцэтгэн, компанийн эрх ашиг болон сайн засаглалын зарчимд нийцүүлэн оновчтой зохицуулалт хийх;
  - 2.9.11. Хувьцаа эзэмшигчид нь гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаанд хэт нөлөөлөхгүй байх зарчмыг мөрдүүлэх;
  - 2.9.12. Компанийн дүрэм, хувьцаа эзэмшигчдийн хурлаас эрх олгосон бусад асуудал, түүнчлэн Компанийн тухай хууль, компанийн дүрмээр хувьцаа эзэмшигчдийн хурал, гүйцэтгэх удирдлагын эрхэд хамааруулснаас бусад, ТУЗ шаардлагатай гэж үзсэн асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх;
  - 2.9.13. Хууль тогтоомж, Компанийн дүрэм, журамд заасан бүрэн эрх.
- 2.10. Хууль тогтоомжид заасны дагуу ТУЗ-ийн шууд бүрэн эрхийн хүрээнд хамаарах асуудлыг Гүйцэтгэх захирал болон хороодод итгэмжлэн шилжүүлэхгүй бөгөөд харин энэхүү журмын 2.9.3-т заасан хэлцэлд үл хамаарах, компанийн үндсэн үйл ажиллагаанд хамаарах хэлцэл байгуулах эрхийг Гүйцэтгэх удирдлагын багт шилжүүлсэн болно.
- 2.11. Компанийн тухай хуульд заасан хугацаанд хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулаагүй бол хувьцаа эзэмшигчдийн хуралд бэлтгэж, зарлан хуралдуулах чиг үүргийг хэрэгжүүлэхээс бусад ТУЗ-ийн бүрэн эрх дуусгавар болно.

#### **ГУРАВ. ТУЗ-ИЙН ГИШҮҮНД ТАВИГДАХ ШААРДЛАГА**

- 3.1 Компанийн ТУЗ-ийн гишүүн нь дараах шаардлагыг хангасан хувь хүн байна:
  - 3.1.1. мэргэшил, ёс зүйн өндөр шаардлага хангасан, бизнесийн удирдлагын дадлага туршлагатай;
  - 3.1.2. төрийн болон нутгийн захиргааны байгууллага, цэрэг, цагдаа, шүүх, прокурорын байгууллагад удирдах албан тушаал зэрэг хашдаггүй байх;
  - 3.1.3. ял шийтгэлгүй;
  - 3.1.4. компанийн засаглалын чиглэлээр сургалтанд хамрагдаж, гэрчилгээ авсан байх.
- 3.2 ТУЗ-ийн гишүүн нь Компанийн тухай хууль, энэ журамд заасан шаардлагыг хангасан Монгол Улсын болон гадаад улсын иргэн, харьяалалгүй хүн байж болох бөгөөд компанийн хувьцаа эзэмшигч (хуульд зааснаас бусад тохиолдолд) байж болно.
- 3.3 Хараат бус гишүүн нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:
  - 3.3.1. өөрөө, эсхүл нэгдмэл сонирхолтой этгээлтэй хамтран компанийн нийт гаргасан хувьцааны 5 болон түүнээс дээш хувийг эзэмшдэггүй;
  - 3.3.2. өөрөө, эсхүл нэгдмэл сонирхолтой этгээд нь компанид болон компани оролцогч нь болж байгаа нэгдлийн бусад оролцогч компанид эрх бүхий албан тушаал хашдаггүй, эсхүл сүүлийн 3 жилд тийм албан тушаал хашаагүй;
  - 3.3.3. компанитай бизнесийн аливаа холбоогүй;



- 3.3.4. компанийн эрх бүхий албан тушаалтантай нэгдмэл сонирхолгүй, тэдгээрийн төрөл, садан, гэр бүлийн гишүүн биш;
- 3.3.5. төрийн үйлчилгээнээс бусад төрийн алба хашдаггүй.
- 3.4. ТУЗ-ийн хараат бус гишүүдийн нэгээс доошгүй нь мэргэшсэн нягтлан бодогч, эсхүл нягтлан бодох бүртгэл аудитын чиглэлээр магистраас доошгүй зэрэгтэй, мөн чиглэлээр 3-аас доошгүй жил ажилласан туршлагатай хүн байна.
- 3.5. Гүйцэтгэх удирдлагыг хэрэгжүүлэгч этгээд нь ТУЗ-ийн гишүүн байж болох бөгөөд тэдгээр нь нийт ТУЗ-ийн гишүүдийн 1/3-ээс олонгүй байна.

#### **ДӨРӨВ. ТУЗ-ИЙН ГИШҮҮНД НЭР ДЭВШҮҮЛЭХ, СОНГОХ, ЧӨЛӨӨЛӨХ**

- 4.1 ТУЗ-ийн цалин урамшуулал, нэр дэвшүүлэх хороо нь компанийн эрх бүхий албан тушаалтанд нэр дэвшүүлэх боломжтой этгээдийн талаар судалгаа хийж, мэдээлэл цуглуулах, уулзалт ярилцлага хийх, нөөцийн бүртгэлд бүртгэх зэрэг арга хэмжээг байнга хэрэгжүүлнэ. Цалин урамшуулал, нэр дэвшүүлэх хороо нь нөөцийн бүртгэлд бүртгэгдсэн хүмүүсээс тэргүүн ээлжинд ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийн жагсаалтад оруулах, Компанийн тухай хууль болон энэ журамд зааснаар ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлэх этгээдийн талаар санал гаргах эрх бүхий этгээдийн санал болгосон этгээд хууль болон энэ журмаар тогтоосон шалгуурыг хангаж байгаа эсэхийг хянах, санал болгосон нэр дэвшигчийг жагсаалтад бүртгэх эсэх асуудлыг шийдвэрлэх бүрэн эрхтэй.
- 4.2 Саналын эрх бүхий энгийн хувьцааны 5 буюу түүнээс дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч саналаа ТУЗ-ийн цалин урамшуулал, нэр дэвшүүлэх хороонд гаргах замаар нэр дэвшүүлэх эрхээ хэрэгжүүлж болно. Түүнчлэн компанийн засаглалыг хөгжүүлэх зорилгоор идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй Төрийн бус байгууллага хараат бус гишүүнд тавигдах шаардлага хангасан хүмүүсийн талаарх мэдээллийг ТУЗ-ийн цалин урамшуулал, нэр дэвшүүлэх хороонд ирүүлж болно. Хараат бус гишүүнд нэр нь дэвшиж буй этгээд зөвшөөрлөө бичгээр өгсөн байх бөгөөд хууль болон энэ журамд заасан шалгуурыг хангаж байгаа гэдгээ албан ёсоор баталгаажуулсан байна. Энэхүү баталгааг хуурамчаар гаргасан нь тогтоогдвол ТУЗ-ийн дарга энэ талаар хувьцаа эзэмшигчдэд мэдээлэх үүрэгтэй.
- 4.3 Хувьцаа эзэмшигч өөрийн нэрийг ТУЗ-ийн гишүүнд дэвшүүлж болно.
- 4.4 Энэ журмын 4.2, 4.3-т заасан этгээд ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлэх саналаа жил бүрийн 3 дугаар сарын 1-ний дотор ТУЗ-ийн цалин урамшуулал, нэр дэвшүүлэх хороонд бичгээр ирүүлэх бөгөөд ердийн гишүүн, хараат бус гишүүний алинд нь нэр дэвшүүлж байгаагаа болон энэ журамд заасан шаардлагыг нэр дэвшигч хэрхэн хангаж байгаа тухай мэдээллийг нотлох баримтын хамт ирүүлнэ. Саналд энэ журмын 5 дугаар хавсралтаар баталсан “Нэр дэвшигчийн баталгаа”, 6 дугаар хавсралтаар баталсан “Инновэйшн Инвестмент” ХК –ийн эрх бүхий албан тушаалтны нэгдмэл сонирхолтой этгээдийн мэдэгдэл 7 дугаар хавсралтаар баталсан “Нэр дэвшигчийн анкет” зэргийг хавсаргасан байна.
- 4.5 Нэр дэвшигч нь компанийн ТУЗ-ийн дэргэдэх цалин урамшуулал, нэр дэвшүүлэх хороонд дараах мэдээллийг үнэн зөвөөр ирүүлэх үүрэгтэй бөгөөд цалин урамшуулал, нэр дэвшүүлэх хороо нь уг мэдээллийг хувьцаа эзэмшигчдийн хуралд зориулан хувьцаа эзэмшигчдэд заавал хүргүүлнэ. Үүнд:
- 4.5.1 нэр дэвшигчийн овог, нэр;
- 4.5.2 нэр дэвшигчийн нас, боловсролын байдал, ажилласан туршлага болон бусад дэлгэрэнгүй мэдээлэл;



- 4.5.3 нэр дэвшигчийн сүүлийн 5 (тав) жилийн хугацаанд эрхэлж байсан ажил, албан тушаал;
  - 4.5.4 нэр дэвшүүлэх үед түүний эрхэлж байгаа ажил, албан тушаал, сонгуульт ажлууд;
  - 4.5.5 нэр дэвшигч, компанийн хоорондын харилцан хамаарал байгаа эсэх;
  - 4.5.6 нэр дэвшигч нь компанийн нэгдмэл сонирхолтой этгээдтэй ямар нэг хамааралтай эсэх;
  - 4.5.7 компанийн томоохон бизнесийн түншүүдтэй ямар нэг хамааралтай эсэх;
  - 4.5.8 нэр дэвшигчийн орлогын эх үүсвэр, болон түүний ТУЗ-ийн гишүүний ажил үүрэгт нөлөөлөхүйц бусад нөхцөл байдлын талаарх мэдээлэл.
- 4.6 ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлэхээр ирүүлсэн санал, түүнд хавсаргасан баримтуудын бүрдлийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга хянаж хүлээн авах бөгөөд саналыг хүлээн авсанаас хойш ажлын 1 хоногийн дотор цалин урамшуулал, нэр дэвшүүлэх хорооны даргад танилцуулна. Цалин урамшуулал, нэр дэвшүүлэх хорооны дарга ирүүлсэн бичиг баримтад үндэслэн тухайн хүнийг нэр дэвшигчдийн жагсаалтад бүртгэх эсэх тухай санал, үндэслэлээ цалин урамшуулал, нэр дэвшүүлэх хорооны хуралд ажлын 3 хоногийн дотор танилцуулна. Цалин урамшуулал, нэр дэвшүүлэх хорооны дарга энэ үүргийг аль нэг гишүүндээ даалгаж болно. Цалин урамшуулал, нэр дэвшүүлэх хорооны гишүүдийн олонхийн саналаар нэр дэвшигчийг жагсаалтад оруулж бүртгэх тухай шийдвэр гаргана. Тухайн нэр дэвшигчийг жагсаалтад оруулж бүртгэхээс татгалзсан тохиолдолд үндэслэлээ нэр дэвшүүлсэн этгээдэд бичгээр мэдэгдэнэ. Нэр дэвшүүлсэн этгээд тийнхүү татгалзсан шийдвэрийг үндэслэлгүй гэж үзвэл бичгээр мэдэгдэл хүлээн авснаас хойш ажлын 3 хоногийн дотор ТУЗ-ийн даргад гомдол гаргах эрхтэй. ТУЗ-ийн дарга хувьцаа эзэмшигчийн гомдлыг хүлээн авснаас хойш ажлын 5 хоногт багтаан асуудлыг ТУЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэр гаргана. ТУЗ-ийн шийдвэр эцсийнх байна.
- 4.7 Нэр дэвшигчийг жагсаалтад бүртгэхээс дараах үндэслэлээр татгалзаж болно. Үүнд:
- 4.7.1 Нэр дэвшигч нь хууль, энэ журамд заасан шаардлагыг хангаагүй;
  - 4.7.2 Нэр дэвшигч өмнө нь компанийн ТУЗ-ийн гишүүнээр ажиллаж байхдаа “хангалтгүй ажилласан” гэсэн үнэлэлт, дүгнэлт авсан бол уг дүгнэлт гарснаас хойш 3 жил өнгөрөөгүй байгаа.
- 4.8 ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийн жагсаалтад бүртгэгдсэн хүний нэрийг хувьцаа эзэмшигчдийн хурлын санал авах хуудсанд оруулах бөгөөд энэ журмын 7 дугаар хавсралтаар баталсан нэр дэвшигчийн анкетыг хувьцаа эзэмшигчдийн хуралд зориулсан мэдээлэлд оруулсан байна.
- 4.9. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар энгийн болон хараат бус гишүүдэд нэр дэвшигчдийг 2 ангилж кумулятив аргаар санал хураах ба энэ журмын 4 дүгээр зүйлийн холбогдох хэсэгт заасны дагуу санал болгосон, тухайн ангилалд хамгийн олон санал авч дэмжигдсэн нэр дэвшигчийг ТУЗ-ийн гишүүнээр сонгоно.
- 4.10. ТУЗ-ийн гишүүний бүрэн эрхийг дараах тохиолдолд Хувьцаа эзэмшигчдийн хурлаас хугацаанаас нь өмнө дуусгавар болгоно.
- 4.10.1. Гишүүн өөрөө хүсэлт гаргасан;
  - 4.10.2. Эрүүл мэндийн хувьд тэнцэхгүй болсон, нас барсан;
  - 4.10.3. Гэмт хэрэгт холбогдож, шүүхээс таслан шийдвэрлэх шийтгэх тогтоол гарсан;
  - 4.10.4. Компанийн эрх ашгийн эсрэг үйл ажиллагаа явуулсан;



- 4.10.5. ТУЗ-ийн гишүүнд тавигдах шаардлагыг хангахгүй болсон;
  - 4.10.6. ТУЗ-ийн гишүүн нь Компанийн тухай хууль, Компанийн дүрэм, хувьцаа эзэмшигчтэй байгуулсан аливаа хэлцэл болон энэхүү журмаар хүлээсэн үүргээ ноцтой зөрчсөн;
  - 4.10.7. Өөрийн бүрэн эрх, хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхтэй холбоотойгоор ёс зүйн зөрчил гаргасан;
  - 4.10.8. Компанийн ашиг, эдийн засгийн байдлыг уналтанд оруулах үндэслэлгүй шийдвэр гаргасан;
  - 4.10.9. Хувьцаа эзэмшигчдийн итгэлийг алдсан.
- 4.9 ТУЗ-ийн гишүүн удаан хугацаагаар үүргээ хэрэгжүүлж чадахгүй болсон, чөлөөлөгдөх хүсэлтээ гаргасан, нас барсан тохиолдолд орлох гишүүнийг хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдах хүртэл цалин урамшуулал, нэр дэвшүүлэх хорооны саналыг үндэслэн ТУЗ түр томилно. Түр томилогдсон гишүүн нь ТУЗ-ийн хараат бус гишүүнд тавигдах шаардлагыг хангасан байх ба төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний эрхийг эдэлнэ. Цалин урамшуулал, нэр дэвшүүлэх хороо өмнө нь ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшсэн боловч сонгогдож чадаагүй нэр дэвшигчдээс тэргүүн ээлжинд орлох гишүүнээр нөхөн сонгуулахаар нэр дэвшүүлнэ. Дараагийн ХЭХ-аар түр томилогдсон гишүүнийг жинхэлж сонгох эсэхийг шийдвэрлэнэ.
- 4.10 ТУЗ-ийн гишүүдийн тоо нь тогтоосон нийт гишүүдийн тооноос 2 дахин бага болсон тохиолдолд ТУЗ нь 3 сарын дотор ТУЗ-ийн гишүүдийг сонгохоор хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулна.

#### **ТАВ. ТУЗ-ИЙН ГИШҮҮДИЙН ЭРХ, ҮҮРЭГ**

- 5.1 ТУЗ-ийн гишүүнд нэр нь дэвшүүлж байгаа этгээд нь компанийн дүрэм, энэхүү журмыг сайтар судалсан байх бөгөөд ТУЗ-ийн гишүүний хувьд үүргээ бүрэн биелүүлэх өөрийн цаг, боломжийг харгалзан үзэж ТУЗ-ийн гишүүнээр сонгогдоход татгалзах зүйлгүйгээ илэрхийлэн энэхүү журмын 5 дугаар хавсралтын дагуу "Нэр дэвшигчийн баталгааг" үйлдэж гарын үсэг зурж баталгаажуулсан байна.
- 5.2 ТУЗ-ийн гишүүнээр сонгогдсон тохиолдолд Компанийн тухай хууль, компанийн дүрэм, энэхүү журмаар хүлээсэн үүргээ бүрэн биелүүлж, хүчин чармайлт гарган ажиллана.
- 5.3 ТУЗ-ийн гишүүн нь ТУЗ-ийн болон ТУЗ-ийн хороодын хуралд биечлэн оролцоно. Хэрэв ТУЗ-ийн гишүүн хүндэтгэн үзэх шалтгаанаар хуралд биечлэн оролцох боломжгүй бол энэ тухайгаа ТУЗ-ийн нарийн бичгийн даргад урьдчилан мэдэгдэх үүрэгтэй. ТУЗ-ийн гишүүн цахим шуудангаар тараагдсан хурлын материалыг судлаад хэлэлцэх асуудал бүрээр тодорхой санал, дэлгэрэнгүй тайлбараа бичгээр бэлтгэн хурлаар хэлэлцэх асуудлаар санал өгөх эсхүл тухайн хуралд утсаар болон онлайн хэлбэрээр оролцож, саналаа өгснийг хурлын ирц, санал тооллогод оруулан тооцох бөгөөд гишүүн тухайн хуралд оролцсон гэж үзнэ. Хурлаар урьдчилан товлөөгүй асуудлыг хэлэлцэж шийдвэрлэх шаардлагатай нөхцөл үүсч болзошгүй тул гишүүн бүр хуралд биечлэн оролцохыг эрмэлзэнэ.
- 5.4 ТУЗ-ийн гишүүн нь заавал өөрийн цахим шуудангийн хаяг(и-мэйл)-тай байх бөгөөд мэдээллийг уг хаягаараа тогтмол хүлээн авч, хариу өгнө. Үүний тулд гишүүн ажлын өдөр бүр Улаанбаатарын цагаар өглөөний 10 цагаас өмнө цахим шуудангаа шалгах бөгөөд, цахим хаягаа өөрчилбөл энэ тухай дараагийн ажлын өдөрт багтаан ТУЗ-ийн нарийн бичгийн даргад мэдэгдэж бүртгүүлнэ.



- 5.5 ТУЗ-ийн болон ТУЗ-ийн дэргэдэх хороодын тухайн жилийн нийт хуралдааны 30-аас дээш хувьд нь энэ журмын 5.3-т заасан аль нэг хэлбэрээр оролцоогүй гишүүнийг ТУЗ-д дахин нэр дэвшүүлэхгүй.
- 5.6 ТУЗ-өөс гаргаж буй шийдвэр нь мэдээлэл дээр үндэслэсэн, бодитой, компанийн үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, сайн засаглалыг хэвшүүлэх, хөрөнгө оруулагчдын эрх ашгийн тэнцвэрийг хангасан байхын тулд ТУЗ-ийн гишүүдэд шийдвэр гаргах үндэслэл болсон мэдээллийг бүрэн хүргүүлсэн байх бөгөөд гишүүд эдгээр мэдээллийг сайтар судалсан байна.
- 5.7 ТУЗ-ийн гишүүдэд мэдээлэл хүргэх асуудлыг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга хариуцах бөгөөд Аудитын хорооны дарга хяналт тавина. ТУЗ-ийн гишүүд мэдээлэл аваагүй, дутуу, эсхүл хугацаа хожимдож авсан асуудлаар ТУЗ-ийн даргад гомдол гаргах бөгөөд ТУЗ-ийн дарга буруутай этгээдэд хариуцлага хүлээлгэх, ач холбогдлоо алдаагүй мэдээллийг нөхөн хүргүүлэх арга хэмжээг авна.
- 5.8 ТУЗ-ийн гишүүдийн мэдлэг мэргэшлийг дээшлүүлэх талаар ТУЗ-ийн дарга холбогдох арга хэмжээг авна. Үүний тулд уг арга хэмжээний зардлын төсвийг ТУЗ-ийн үйл ажиллагааны зардалд оруулан батлуулах бөгөөд ТУЗ-ийн гишүүдийг хурал зөвлөгөөн, семинарт оролцуулах, мэргэжлийн сэтгүүл, бусад мэдээллээр хангахад уг төсвийг зарцуулна.
- 5.9 ТУЗ-ийн гишүүд нь ТУЗ-өөс урилга хүргүүлсэн тохиолдолд тухайн сургалт, семинар, хурал, зөвлөгөөнд заавал оролцоно. Тухайлан урьсан арга хэмжээний 60 хүрэхгүй хувьд нь оролцсон бол ТУЗ-ийн гишүүнд дахин нэр дэвшүүлэхгүй.
- 5.10 ТУЗ-ийн гишүүн энэ журмын 2.5-д заасан асуудлаар шийдвэр гаргахад шаардлагатай болон Хувьцаа эзэмшигчдийн хурлын бэлтгэлийг хангах, мөн журмын 2.6-д заасан ТУЗ-ийн мониторинг, хяналт шалгалтын чиг үүргийг ТУЗ, түүний хороодын үйл ажиллагааны төлөвлөгөө, ТУЗ-ийн буюу холбогдох Хорооны даргын өгсөн үүрэг, ажил үүргийн хуваарийн дагуу хэрэгжүүлнэ.
- 5.11 Компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь хувьцаа эзэмшигч нарт зориулан жилийн үйл ажиллагаа, бүтэц, зохион байгуулалт, хөрөнгийн талаар тайлан бичиж хүргүүлэх бөгөөд тайланд доорх зүйлийг тусгана:
- 5.11.1. тайлангийн хугацаанд компанийн эрхлэн явуулсан үндсэн үйл ажиллагааны талаарх танилцуулга, гарсан өөрчлөлтүүд болон эдгээр үйл ажиллагааны үр дүнгийн байдал, бүтэц, зохион байгуулалт, түүний өөрчлөлт, санхүүгийн байдал;
- 5.11.2. тайлангийн хугацаанд компанийн эрх бүхий албан тушаалтанд олгосон шагнал урамшуулал удирдлагын зардлын хэмжээ;
- 5.11.3. Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад бүртгэгдсэн, арилжаалагдсан хувьцааны мэдээлэл
- 5.11.4. компанийн дүрмээр тогтоосон бусад мэдээлэл.

### **ЗУРГАА. ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮДИЙН ЭРХ, ҮҮРЭГ**

- 6.1 ТУЗ-ийн хараат бус гишүүд нь энэ журмын 5 дугаар зүйлд зааснаас гадна дараах чиг үүрэгтэй байна:
- 6.1.1. ТУЗ-ийн болон гүйцэтгэх удирдлагын гаргаж буй бүх шийдвэр, түүний дотор их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх тухай шийдвэр нь хувьцаа эзэмшигчдийн тэнцвэртэй ашиг сонирхол, компанийн эрх ашиг, холбогдох хууль



- тогтоомж, компанийн бодлогын баримт бичгээр тодорхойлсон шаардлага, журамд нийцэж байгаа эсэхэд хяналт тавих, зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх;
- 6.1.2. Хувьцаа эзэмшигчид, олон нийтийг мэдээллээр хангах үүргээ гүйцэтгэх удирдлага хэрхэн хэрэгжүүлж байгаад хяналт тавих;
- 6.1.3. Дотоод хяналт зохих шаардлагын түвшинд ажиллаж байгаа эсэхэд хяналт тавих;
- 6.1.4. ТУЗ болон гүйцэтгэх удирдлагын шийдвэр нь хувьцаа эзэмшигчид болон компанийн эрх ашигт сөргөөр нөлөөлөхөөр байна гэж үзвэл энэ талаар бичгээр дүгнэлт хүргүүлж, уг дүгнэлтийн талаар үндэслэл бүхий тайлбар ирүүлээгүй, ирүүлсэн ч тайлбар, үндэслэл нь бодит байдалд нийцэхгүй гэж үзвэл гаргасан зөрчлөө арилгахыг шаардах;
- 6.1.5. Хоёроос доошгүй хараат бус гишүүн хамтран Компанийн тухай хуулийн 61 дүгээр зүйлд заасны дагуу хувьцаа эзэмшигчдийн хурал зарлан хуралдуулахыг шаардах, ТУЗ уг шаардлагыг үндэслэлгүйгээр хүлээн аваагүй тохиолдолд өөрсдөө хурал зарлан хуралдуулах;
- 6.1.6. Хувьцаа эзэмшигчдийн хуралд биечлэн оролцож, ТУЗ-ийн шийдвэрийн талаар зарчмын зөрүүтэй байр суурьтай байсан бол энэ тухайгаа мэдээлж, хувьцаа эзэмшигчдийн асуултад хариулах.
- 6.2. Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүд дараах асуудлыг хэлэлцэхэд заавал оролцож саналаа өгнө. Үүнд:
- 6.2.1. Компанийн тухай хуулийн 55 дугаар зүйлд заасны дагуу эд хөрөнгийн болон эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг тогтоох;
- 6.2.2. аудитын байгууллагыг сонгож, түүнтэй байгуулах гэрээний нөхцөлийг тогтоох;
- 6.2.3. Компанийн тухай хуулийн арван хоёрдугаар бүлэгт тодорхойлсон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгох.
- 6.3. Хараат бус гишүүдийн нэг нь ТУЗ-ийн аудитын хороог даргална. Энэ гишүүн нь нягтлан бодох бүртгэл, аудитын чиглэлээр мэргэшсэн байна.

#### **ДОЛОО. ТУЗ-ИЙН ДАРГЫН БҮРЭН ЭРХ**

- 7.1 ТУЗ-ийн даргыг ТУЗ-ийн гишүүдийн дотроос нийт гишүүдийн олонхийн саналаар сонгоно.
- 7.2 ТУЗ-ийн дарга нь ТУЗ-ийн үйл ажиллагааг зохион байгуулж, хурлыг хуралдуулах, хурал даргалах, хурлын тэмдэглэлийг хөтлүүлэх, ТУЗ-ийн үйл ажиллагаанд хяналт тавих үндсэн чиг үүрэгтэй. ТУЗ-ийн дарга нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.
- 7.2.1. Хууль, компанийн дүрэмд заасан асуудлаар Хувьцаа эзэмшигчдийн хуралд ТУЗ-ийн тайланг тавьж, тавигдсан асуултад хариулах;
- 7.2.2. ТУЗ-аар батлагдсан ТУЗ-ийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлт оруулах санал боловсруулж, хуралд оруулах;
- 7.2.3. ТУЗ-ийн нэгээс илүүгүй хорооны дарга, мөн нэгээс илүүгүй хорооны гишүүнээр сонгогдох, бусад хорооны хуралд зөвлөх эрхтэйгээр оролцох;
- 7.2.4. Гишүүдэд компанийн үйл ажиллагааны үр дүнгээр шагнал урамшуулал олгох санал боловсруулж, ТУЗ-ийн хуралд оруулах;
- 7.2.5. ТУЗ-ийн хурлыг удирдах, өөрөө оролцох боломжгүй бол хурал удирдах этгээдийг томилох;



- 7.2.6. Гишүүдийг гадаад, дотоодын хурал, семинарт оролцуулах асуудлыг шийдвэрлэх;
- 7.2.7. ТУЗ-ийн үйл ажиллагааны үр дүн, төлөвлөгөөний биелэлтийг хариуцах.
- 7.2.8. ХЭХ-аас эрх олгосон болон ТУЗ шаардлагатай гэж үзсэн бусад.
- 7.3 ТУЗ-ийн дарга нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуулиар тогтоосон хугацаанд хуралдуулж, жилийн үйл ажиллагааны тайланг хэлэлцүүлэх, “Хувьцаа эзэмшигчдийн хурлын зар мэдээ хүргэх журам”-д заасны дагуу хурлын бэлтгэлийг хангах асуудлыг биечлэн зохион байгуулж, хянах онцгой үүрэг хүлээнэ.
- 7.4 ТУЗ-ийн дарга нь гүйцэтгэх удирдлагыг хэрэгжүүлэгч этгээд байхыг хориглоно.
- 7.5 ТУЗ-ийн даргын түр эзгүйд түүний үүргийг ТУЗ-ийн даргын эсхүл ТУЗ-өөс томилсон гишүүн гүйцэтгэнэ.

#### **НАЙМ. ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА, ТҮҮНИЙ ҮҮРЭГ**

- 8.1 ТУЗ-ийн нарийн бичгийн даргыг ТУЗ-ийн даргын санал болгосноор ТУЗ томилно.
- 8.2 Нарийн бичгийн даргад нэр дэвшигч дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:
- 8.2.1. Дээд боловсролтой (эрх зүйч мэргэжилтэй бол давуу тал болно);
- 8.2.2. Нарийн бичгийн даргын үүрэг хариуцлагыг гүйцэтгэхэд шаардлагатай бичиг хэрэг, мэдээллийн технологи, гадаад хэлний зохих мэдлэгтэй, мэргэжлийн чадвар, туршлагатай;
- 8.2.3. Ажил хэргийн болон хувь хүний нэр хүндийн хувьд компанийн хувьцаа эзэмшигчид, харилцагч талуудын итгэлийг хүлээхүйц ;
- 8.2.4. Компанийн засаглалын чиглэлээр сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан.
- 8.3 ТУЗ-ийн гишүүд нь нарийн бичгийн даргын албан тушаалд нэр дэвшигчтэй холбоотой дараах мэдээлэлтэй танилцсан байна. Үүнд:
- 8.3.1. Нэр дэвшигчийн боловсрол, ажлын туршлага;
- 8.3.2. Нэр дэвшигч компанийн хувьцаа эзэмшдэг эсэх (хэрвээ эзэмшдэг бол хувьцааны төрөл, тоо хэмжээ);
- 8.3.3. Компанийн нэгдмэл сонирхолтой этгээд мөн эсэх;
- 8.3.4. Компанид нэр дэвшигчтэй нэгдмэл сонирхолтой этгээд байгаа эсэх;
- 8.3.5. Энэхүү албан тушаалыг хашихад ноцтойгоор нөлөөлөх бусад шаардлагатай мэдээлэл.
- 8.4 ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь компанийн дүрэмд заасан болон дараах чиг үүрэгтэй байна. Үүнд:
- 8.4.1. Компанийн засаглалын бодлогыг дагаж мөрдүүлэх, компанид сайн засаглалын практикийг хэвшүүлэх үйл явцыг компанийн хэмжээнд удирдан чиглүүлэх арга хэмжээ авах, энэ талаар компанийн Дотоод хяналт, эрсдлийн удирдлагын албатай хамтран ажиллах;
- 8.4.2. Компанийн сайн засаглалын талаар олон улсын болон бусад компанийн туршлага, төрийн болон төрийн бус байгууллагаас энэ талаар дэвшүүлж буй санал санаачилгыг судлах замаар өөрийн компанийн засаглалыг цаашид сайжруулах санал боловсруулах;



- 8.4.3. Хувьцаа эзэмшигчдийн хурал, ТУЗ, ТУЗ-ийн хороодын хуралд бэлтгэх, хэлэлцэх асуудал, танилцуулга, гарах шийдвэрийн төслийг бэлтгэх буюу, хянах, хурал зарлах, хуралдуулах, эцнээ санал хураалт явуулах бүхий л арга хэмжээг зохион байгуулах;
- 8.4.4. Хувьцаа эзэмшигчдийн, ТУЗ-ийн болон хороодын хурлын тэмдэглэлийг хөтлөх, гарах шийдвэрийг зохих журмын дагуу баталгаажуулах, хэрэгжилтэд хяналт тавьж, ТУЗ-ийг мэдээллээр хангах;
- 8.4.5. Хувьцаа эзэмшигчид, ТУЗ, гүйцэтгэх удирдлага болон бусад оролцогч талуудын үйл ажиллагааны уялдааг хангах, мэдээлэл солилцох тогтолцоог хариуцах;
- 8.4.6. Мэдээллийг хувьцаа эзэмшигчид, олон нийтэд хүргэх зохион байгуулалтын арга хэмжээ авах замаар компанийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангах, хэрэв энэ асуудлыг хариуцсан ажилтантай бол үйл ажиллагаанд нь хяналт тавих;
- 8.4.7. Хувьцаа эзэмшигч болон бусад оролцогч талаас ТУЗ-д ирүүлсэн аливаа санал, гомдол хүсэлтийг шийдвэрлэхэд оролцох, компани доторх маргааныг шийдвэрлэх талаар санал боловсруулж, холбогдох арга хэмжээ авах;
- 8.4.8. Хувьцаа эзэмшигчид болон эрх бүхий сонирхогч этгээдэд компанийн тухай хууль тогтоомж, дүрмээр тогтоосон мэдээлэл авах эрхээ хэрэгжүүлэх боломж олгох;
- 8.4.9. ТУЗ-ийн дотоод ажлыг хариуцан зохион байгуулах;
- 8.4.10. Компанийн ТУЗ-ийн дарга, гишүүн, компанийн энгийн хувьцааны 10 буюу түүнээс дээш хувийг дангаараа буюу бусад этгээдтэй хамтран эзэмшдэг этгээд, гүйцэтгэх захирал, дэд захирал, ерөнхий нягтлан бодогч зэрэг компанийн эрх бүхий албан ажилтанд нэр дэвшигчийн нэгдмэл сонирхолтой этгээдийн мэдэгдэл, анкетыг хүлээн авч, ТУЗ-ийн цалин урамшуулал, нэр дэвшүүлэх хороонд танилцуулах;
- 8.4.11. Ажлаа ТУЗ-д тайлагнах зэрэг дүрэм, дотоод бичиг баримтаар тодорхойлсон бусад.
- 8.5 ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь охин компанийн ТУЗ-ийн нарийн бичгийн даргын үүргийг гүйцэтгэж болох бөгөөд ийнхүү гүйцэтгээгүй тохиолдолд охин компанийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нарыг мэргэжил, арга зүйн удирдлагаа зохицуулалтаар хангаж, хамтран ажиллана.
- 8.6 ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь ТУЗ-ийн болон хороодын бүх бичиг хэргийг хөтлөх ажлыг хариуцан зохион байгуулна.
- 8.7 ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь ТУЗ-ийн болон хороодын хурлын бэлтгэлийг хангаж, хурлын зар, хэлэлцэх асуудалтай холбоотой мэдээлэл, гарах шийдвэрийн төслийг гишүүдэд бичгээр эсхүл цахим шуудангаар хурал хуралдахаас ажлын 5-аас доошгүй өдрийн өмнө хүргэнэ. Шаардлагатай тохиолдолд хурлын зар, хэлэлцэх асуудалтай холбоотой мэдээлэл, гарах шийдвэрийн төслийг гадаад хэлээр үйлдэж хүргүүлнэ.
- 8.8 ТУЗ-ийн болон хороодын хурлын ирцийг бүртгэн тухай бүр хурал даргалагчаар гарын үсэг зуруулна.
- 8.9 ТУЗ-ийн гишүүдэд мэдээлэл хүргэх, хурал, семинарын урилга хүргэх зэрэг асуудлыг биечлэн хариуцна.
- 8.10 ТУЗ-ийн гишүүд нь хүндэтгэх шалтгааны улмаас ТУЗ-ийн болон хороодын хурал, эсхүл урилга ирүүлсэн хурал, семинарт оролцож чадахгүй бол энэ тухайгаа ТУЗ-ийн нарийн бичгийн даргад заавал урьдчилан мэдэгдэнэ.
- 8.11 ТУЗ-ийн нарийн бичгийн даргын эзгүйд түүний үүргийг орлох этгээдийг ТУЗ-ийн дарга томилно.



- 8.12 ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь ТУЗ-ийн хороодын нарийн бичгийн даргын үүргийг гүйцэтгэнэ.

### **ЕС. ТУЗ-ИЙН ГИШҮҮДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ДҮГНЭХ**

- 9.1 ТУЗ-ийн гишүүдийн үйл ажиллагаанд цалин урамшуулал, нэр дэвшүүлэх хороо үнэлэлт, дүгнэлт өгнө.
- 9.2 Цалин урамшуулал, нэр дэвшүүлэх хороо нь ТУЗ-ийн гишүүдийн хурал, зөвлөгөөн, семинарт оролцсон ирц, идэвх, санаачилга, ТУЗ, харьяалах хорооноос өгсөн үүрэг даалгаврыг хэрхэн биелүүлсэн, ажлаа тайлагнасан байдал зэрэг үзүүлэлтийг харгалзан үнэлэлт, дүгнэлт өгнө.
- 9.3 ТУЗ-ийн гишүүн бүрээр ТУЗ-ийн нарийн бичгийн даргын гаргаж өгсөн бүртгэл, хороодын дарга нарын гаргасан тодорхойлолтыг үндэслэн цалин урамшуулал, нэр дэвшүүлэх хорооны гаргасан дүгнэлтийг тухайн тайлангийн жилийн дараагийн жилийн эхний сарын ТУЗ-ийн хуралд танилцуулна.
- 9.4 Цалин урамшуулал, нэр дэвшүүлэх хороо ТУЗ-ийн гишүүнийг үүрэгт ажлаа тайлант хугацаанд “хангалтгүй гүйцэтгэсэн” гэж үнэлсэн бол энэ тухай бичгээр гаргасан дүгнэлт, түүнд тухайн гишүүний бичгээр гаргасан тайлбарыг хавсарган ТУЗ-д танилцуулна.

### **АРАВ. ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД, ТЭДГЭЭРИЙН ЧИГ ҮҮРЭГ**

- 10.1 ТУЗ нь Цалин урамшуулал, нэр дэвшүүлэх хороо, Аудитын хороо, Эрсдэл /комплаенс/-ийн удирдлагын хороо, Стратеги ба хөгжлийн хороо гэсэн байнгын хороодтой байна. ТУЗ нь шаардлагатай тохиолдолд тодорхой асуудал хариуцсан, тусгай чиг үүрэг бүхий түр болон байнгын хороог байгуулж болно.
- 10.2 ТУЗ-ийн хороод нь өөрсдийн чиг үүрэгт хамаарах асуудлаар дүгнэлт гаргаж, төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулах, хууль, компанийн дүрэмд заасан зарим асуудлаар шийдвэр гаргах бүрэн эрхтэй.
- 10.3 Хороодын үйл ажиллагаа, хурлыг ТУЗ-ийн дарга, нарийн бичгийн дарга нар уялдуулан зохион байгуулна.
- 10.4 ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь хороодын нарийн бичгийн даргын үүргийн гүйцэтгэнэ.

#### **Цалин урамшуулал, нэр дэвшүүлэх хороо**

- 10.5 Цалин урамшуулал, нэр дэвшүүлэх хороо нь 3-аас доошгүй гишүүнтэй байх бөгөөд гишүүдийн 2/3 нь хараат бус гишүүн байна.
- 10.6 ТУЗ-ийн цалин урамшуулал, нэр дэвшүүлэх хороо нь дараах чиг үүрэгтэй байх бөгөөд тухайн асуудлаар санал, дүгнэлт боловсруулан ТУЗ-д танилцуулна. Үүнд: Компанийн ТУЗ-ийн гишүүн болон гүйцэтгэх удирдлагад нэр дэвшигчид тавих шаардлагыг тодорхойлж, тэдний ур чадвар, мэдлэг боловсрол, ажлын туршлага зэргийг үнэлэх шалгуурыг тогтоох;
- 10.6.1. ТУЗ болон гүйцэтгэх удирдлагад нэр дэвшигчдийн ур чадвар, мэдлэг боловсрол, ажлын туршлагад үнэлэлт, дүгнэлт өгөх;
- 10.6.2. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүн нь энэ журамд заасан шаардлагыг хангаж байгаа эсэхэд үнэлэлт, дүгнэлт өгөх, Компанийн тухай хуулийн 81.5.7-д



- заасан болон нэр дэвшигчид тавигдах шаардлага хангаагүй гэдэг үндэслэлээр нэр дэвшүүлэхээс татгалзах, тийнхүү татгалзсан бол нэр дэвшигч болон нэр дэвшүүлэхээр санал болгосон этгээдэд мэдэгдэх;
- 10.6.3. ТУЗ-д нэр дэвшигчийг сонгон шалгаруулж, хувыцаа эзэмшигчдийн хуралд шууд нэр дэвшүүлэх /саналын хуудсанд шууд нэрийг нь оруулах/
- 10.6.4. ТУЗ-ийн гишүүдийн үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх зарчмыг тодорхойлж, үнэлэлт дүгнэлт өгөх;
- 10.6.5. Гүйцэтгэх удирдлагад нэр дэвшүүлэх, түүнтэй байгуулах гэрээний нөхцөлийг, түүний дотор цалин, шагнал урамшууллыг тогтоох;
- 10.6.6. Компанийн ТУЗ-ийн гишүүдээс бусад эрх бүхий албан тушаалтны ажлын гүйцэтгэлд гүйцэтгэх захирлаас өгсөн үнэлгээтэй танилцаж, дүгнэлт гаргах;
- 10.6.7. Компанийн ТУЗ-ийн гишүүд, гүйцэтгэх удирдлагын цалин, урамшууллын талаар баримтлах бодлогыг батлах, тогтмол судалгаа хийж, бодлогын хэрэгжилтэд хяналт тавих;
- 10.6.8. ТУЗ-ийн гишүүд, гүйцэтгэх захирал болон бусад эрх бүхий албан тушаалтанд олгох цалин, урамшууллын дээд хязгаарыг тогтоох, тогтоосон хэмжээнд багтаан цалин, урамшуулал олгох санал боловсруулах;
- 10.6.9. Компанид мөрдөж буй ажлын үр дүнтэй холбосон аливаа урамшууллын системийн зорилгыг тодорхойлж, үр дүнг үнэлэх;
- 10.6.10. Ажиллагсдын тэтгэврийн даатгалын болон хувыцаа эзэмшүүлэх аливаа хөтөлбөрийг судалж, сонголт хийх;
- 10.6.11. ТУЗ-өөс үүрэг болгосон болон Компанийн дүрэмд заасан бусад асуудал.
- 10.7 Цалин урамшуулал, нэр дэвшүүлэх хороо нь ТУЗ-ийн гишүүн болон гүйцэтгэх захиралд нэр дэвшигч тус бүрээр сонгон шалгаруулсан үндэслэлээ ТУЗ-ийн хуралд заасан хугацаанд танилцуулна.
- 10.8 Энэ журмын дагуу үнэлэлт дүгнэлт өгсөн тухай тайлангаа ТУЗ-ийн хуралд заасан хугацаанд танилцуулна.
- 10.9 Цалин урамшуулал, нэр дэвшүүлэх хороо нь жилд нэгээс доошгүй удаа ТУЗ-д ажлаа тайлагнах бөгөөд ТУЗ-ийн хурал цалин урамшуулал, нэр дэвшүүлэх хорооны тайланг хэлэлцэн дүгнэлт гаргана.
- 10.10 Цалин урамшуулал, нэр дэвшүүлэх хороо нь энэ журмаар тогтоосон үүргээ хэрэгжүүлээгүй эсхүл хангалтгүй хэрэгжүүлсэн гэж ТУЗ үзвэл цалин урамшуулал, нэр дэвшүүлэх хорооны даргыг, үндэслэлтэй бол гишүүдийг эсхүл аль нэг гишүүний үйл ажиллагаанд “хангалтгүй” гэсэн дүгнэлт өгөх шийдвэр гаргаж болно. Ийм дүгнэлт өгсөн бол уг этгээдийн нэрийг ТУЗ-д дахин дэвшүүлэхгүй.

#### **Аудитын хороо**

- 10.11 Аудитын хороо нь 3 гишүүнтэй байх бөгөөд хорооны дарга болон гишүүдийн 2/3 нь хараат бус гишүүн байна.
- 10.12 Аудитын хороо нь дараах чиг үүрэгтэй байх бөгөөд тухайн асуудлаар дүгнэлт гарган ТУЗ-д танилцуулна. Үүнд:



- 10.12.1. Компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг, бүртгэл нь олон улсын болон үндэсний стандартад нийцэж байгаа эсэх, дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаанд хяналт тавих;
  - 10.12.2. Санхүүгийн тайлан, санхүү-эдийн засгийн бусад мэдээллийн үнэн бодит байдалд хяналт тавих;
  - 10.12.3. Дотоод хяналтын албаны удирдлага, ажилтныг томилох, цалин, урамшууллыг тогтоох талаар гүйцэтгэх захирлын саналыг хянах, санал дүгнэлт гаргах;
  - 10.12.4. Хөндлөнгийн аудитын байгууллагатай харилцах бодлогыг боловсруулж, ТУЗ-аар батлуулах, түүнийг хэрэгжүүлэх, хөндлөнгийн аудитыг сонгох, түүний ажлын хөлсний хэмжээг тогтоох, уг байгууллагаас хийх шалгалтын болон гаргах дүгнэлтийн чиглэлийг тогтоох талаар санал боловсруулах;
  - 10.12.5. Их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэлд хяналт тавих;
  - 10.12.6. Компанийн үйл ажиллагаа нээлттэй, ил тод байгаа эсэх, хууль болон эрх бүхий байгууллагаас тогтоосон мэдээллийг нийтийн хүртээл болгож байгаа байдалд хяналт тавих;
  - 10.12.7. ТУЗ-өөс үүрэг болгосон болон Компанийн дүрэмд заасан бусад асуудал.
- 10.13 Аудитын хороо нь санхүүгийн мэдээллийн болон нягтлан бодох бүртгэлийн асуудлаар хөндлөнгийн аудитор болон дотоод хяналтын албатай байнга санал солилцдог байна.
- 10.14 Дотоод хяналтын албаны ажилтнуудын мэдлэг боловсрол, мэргэшил, дадлага туршлага, хараат бус байдалд тавих шаардлагыг тодорхойлж, тэдний ажлын үр дүнг үнэлэх шалгуур тогтоох асуудлаар гүйцэтгэх захирлын боловсруулсан саналын талаар дүгнэлт гаргана.
- 10.15 Дотоод хяналтын тогтолцоо нь үр дүнтэй байгаа эсэхэд хяналт тавьж дүгнэлт өгнө.
- 10.16 Аудитын хороо нь жилд нэгээс доошгүй удаа ТУЗ-д ажлаа тайлагнах бөгөөд ТУЗ-ийн хурал аудитын хороо хорооны тайланг хэлэлцэн дүгнэлт гаргана.
- 10.17 Хувьцаа эзэмшигчдийг мэдээллээр хэрхэн хангаж байгаа, олон нийтэд болон эрх бүхий байгууллагад хүргэхээр хууль, журам болон "Монголын компанийн засаглалын кодекс"-т заасан мэдээллийг хэрхэн хүргэж байгаа байдалд хяналт тавих үүргийг ТУЗ-ийн Аудитын хороо хэрэгжүүлнэ.
- 10.18 Компанийн үйл ажиллагааны ил тод байдлыг ханган ажиллаагүй байна гэж Аудитын хороо үзвэл хариуцсан эрх бүхий албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх болон цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх саналаа ТУЗ-д оруулан хэлэлцүүлнэ.

#### **Эрсдэл /комплаенс/-ийн удирдлагын хороо**

- 10.19 Эрсдэл /комплаенс/-ийн удирдлагын хороо нь 3-аас доошгүй гишүүнтэй байх бөгөөд гишүүдийн 2/3 нь хараат бус гишүүн байна.
- 10.20 ТУЗ-ийн Эрсдэл /комплаенс/-ийн удирдлагын хороо нь дараах чиг үүрэгтэй байх бөгөөд тухайн асуудлаар санал, дүгнэлт боловсруулан ТУЗ-д танилцуулна. Үүнд:
- 10.20.1. Компанийн эрсдэлийн удирдлага, хяналтын тогтолцоог бүрдүүлэх, эрсдлийн удирдлагын бодлого, зохицуулалтын орчныг тодорхойлох, холбогдох хэм хэмжээг батлах, түүний хэрэгжилтэнд хяналт тавих;
  - 10.20.2. Компанийн эрсдлийн удирдлагын үйл ажиллагааг оновчтой удирдан чиглүүлэх;
  - 10.20.3. Компанийн үйл ажиллагааны гүйцэтгэл, эрсдлийн түвшинд хяналт тавих;



- 10.20.4. Компанийн эрсдэлийн хяналтын үйл ажиллагааг, сайжруулах, боловсронгуй болгох, цар хүрээг нь өргөжүүлэх асуудлаар зөвлөмж боловсруулах;
- 10.20.5. Эрсдэлийн удирдлагын бодлого, журамд тодорхойлсон эрсдэлийн төрлүүдээр алдагдал, хохирлын түвшинг хянах, Компанийн эрсдэл даах чадварыг үнэлэх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, түүнийг бууруулах, хяналтын тогтолцооны найдвартай байдалд хяналт тавих;
- 10.20.6. ТУЗ-өөс үүрэг болгосон болон Компанийн дүрэмд заасан бусад асуудал.
- 10.21 Эрсдэл /комплаенс/-ийн удирдлагын хороо нь жилд нэгээс доошгүй удаа ТУЗ-д ажлаа тайлагнах бөгөөд ТУЗ-ийн хурал эрсдэл /комплаенс/-ийн удирдлагын хорооны тайланг хэлэлцэн дүгнэлт гаргана.

#### **ТУЗ-ийн хороодын хурал**

- 10.22 ТУЗ-ийн хороодын үйл ажиллагаа явуулах үндсэн хэлбэр нь Хорооны хурал байна.
- 10.23 Хороо чиг үүргээ цаг хугацаа алдалгүй хэрэгжүүлэх үүднээс Хорооны хурлыг Хорооны дарга, аль нэг гишүүн, эсхүл ТУЗ-ийн шийдвэрээр хэдийд ч хэдэн ч удаа хуралдуулж болно.
- 10.24 Хороо улиралд 1 (нэг)-ээс доошгүй удаа заавал хуралдана.
- 10.25 Шаардлагатай үед Хорооны нэмэлт хурлыг зарлан хуралдуулж болно. Дотоод болон хөндлөнгийн аудиторын хүсэлтээр хурлыг зарлан хуралдуулах асуудлыг Хорооны дарга хариуцна.
- 10.26 Хорооны хуралд Хорооны гишүүд биечлэн оролцох, эсхүл хуралд оролцох хэлбэрээ бичгээр мэдэгдэх үүрэгтэй. Хурлыг эчнээ санал хураалтаар, эсхүл цахим хэлбэрээр явуулж болно.
- 10.27 Хорооны хуралд гишүүдийн дийлэнх олонх оролцсоноор хурлын ирц бүрдсэн гэж үзнэ.
- 10.28 Хорооны хуралд хэлэлцэх асуудалтай холбогдуулан гүйцэтгэх удирдлагын төлөөллийг оролцуулж болно.
- 10.29 ТУЗ-ийн нарийн бичгийн дарга хурал болон хэлэлцэх асуудлыг хорооны гишүүдэд урьдчилан мэдэгдэж хүргүүлэх үүрэгтэй ба хурал болохоос 3 (гурав) өдрийн өмнө хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд орсон асуудалтай холбоо бүхий шаардлагатай мэдээллийг хэвлэмэл, эсхүл цахим хэлбэрээр хорооны гишүүдэд хүргүүлнэ. (ТУЗ-ийн хурлаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөний загварыг 4 дүгээр хавсралтаас үзнэ үү)
- 10.30 Хороо нь хурлаар хэлэлцэх асуудлыг хэлэлцэж хуралд оролцсон гишүүдийн олонхийн саналаар дүгнэлт, зөвлөмж гаргах ба эдгээрт хуралд оролцсон гишүүд гарын үсэг зурна.
- 10.31 Хорооны аль нэг гишүүн олонхиос өөр саналтай байсан тохиолдолд түүний саналыг хамтад нь ТУЗ-д хүргүүлнэ.
- 10.32 Хороо дүгнэлт, зөвлөмжөө ТУЗ-ийн нарийн бичгийн даргаар дамжуулж ТУЗ-ийн хуралд оруулна.

#### **АРВАН НЭГ. ТУЗ-ИЙН ХУРАЛ**

- 11.1 ТУЗ-ийн хурлыг улиралд нэг удаа хуралдуулна. ТУЗ-ийн гишүүн болон гүйцэтгэх удирдлагын санаачилгаар ээлжит бус хурлыг хэзээ ч зарлан хуралдуулж болно.
- 11.2 ТУЗ-ийн хурлын бэлтгэлийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга хариуцан хангаж, тэмдэглэл хөтөлнө.



- 11.3 ТУЗ-ийн хурлын тухай зар, хэлэлцэх асуудал, түүнтэй холбогдох баримт бичиг, гарах шийдвэрийн төслийг ТУЗ-ийн дарга гарын үсэг зурж баталгаажуулсан байх бөгөөд хурал хуралдахаас ажлын 5-аас доошгүй хоногийн өмнө ТУЗ-ийн нарийн бичгийн дарга хариуцан гишүүдэд бичгээр эсхүл цахим шуудангаар хүргэнэ.
- 11.4 ТУЗ-ийн хурлын шийдвэр нь тогтоол байна. Тогтоолд ТУЗ-ийн дарга гарын үсэг зурж баталгаажуулна. ТУЗ-ийн тогтоолын загварыг 1 дүгээр хавсралтаас үзнэ үү.
- 11.5 ТУЗ-ийн хурлын тогтоол, тэмдэглэлийг Монгол хэл дээр хөтлөх ба ТУЗ-ийн гишүүдийн ойлгох өөр хэлээр мөн үйлдэнэ.
- 11.6 ТУЗ нь албан бичгийн хэвлэмэл хуудас, тэмдэгтэй байх бөгөөд хурлын тэмдэглэл, тогтоолыг албан бичгийн хэвлэмэл хуудсан дээр хэвлэн гаргаж, ТУЗ-ийн дарга болон хурлын тэмдэглэл хөтөлсөн этгээд гарын үсэг зурж, тэмдэг дарж баталгаажуулна. (ТУЗ-ийн хурлын дэлгэрэнгүй тэмдэглэлийн загварыг 3 дугаар хавсралтаас үзнэ үү)
- 11.7 ТУЗ-ийн хурлыг ТУЗ-ийн дарга, түүний гишүүд, компанийн гүйцэтгэх захирал болон дотоод хяналтын алба, хараат бус аудитын байгууллагын санаачилга, шаардлагаар хуралдуулна.
- 11.8 ТУЗ-ийн хурлыг нэг танхимд цугларан биечлэн, эсхүл мэдээллийн технологи ашиглан зайнаас зохион байгуулж болно. Энэ тухай тэмдэглэлд тодорхой тусгаж, шаардлагатай бол зураг, бичлэгээр баталгаажуулна. ТУЗ нь тодорхой асуудлаар эчнээ санал хураалтаар шийдвэр гаргаж болно. Энэ тохиолдолд шийдвэрлэх асуудлын томъёолол, түүнтэй холбогдох бүрэн мэдээлэл, танилцуулгыг ТУЗ-ийн гишүүдэд бичгээр эсхүл цахим шуудангаар хүргүүлэх бөгөөд хүргүүлснээс хойш 5-аас доошгүй хоногийн дараа ТУЗ-ийн гишүүдийн саналыг авахаар заасан байна. Эчнээ санал хураалтаар шийдвэрлэх асуудлаар ТУЗ-ийн гишүүд бичгээр эсхүл цахим шуудангаар саналаа ирүүлэх бөгөөд ТУЗ-ийн гишүүдийн дийлэнх олонх нь саналаа ирүүлсэн, тэдгээрийн дийлэнх олонх нь уг асуудлаар гарах шийдвэрийн төслийг зөвшөөрсөн бол эчнээ санал хураалтаар тухайн асуудлыг шийдвэрлэсэнд тооцож, энэүү журмын 2 дугаар хавсралт загварын дагуу тэмдэглэл хөтөлж, ТУЗ-ийн тогтоол гарган, ТУЗ-ийн дарга гарын үсэг зурж баталгаажуулна. ТУЗ-ийн гишүүд эчнээ санал хураалтаар гаргасан шийдвэрийн албажуулсан хувьтай танилцах эрхтэй.
- 11.9 ТУЗ-ийн хурлыг ТУЗ-ийн дарга удирдана. ТУЗ-ийн дарга хуралд оролцох боломжгүй тохиолдолд түүний томилсон ТУЗ-ийн аль нэг гишүүн хурлыг удирдана. ТУЗ-ийн дарга аливаа этгээдийг томилоогүй бол ТУЗ-өөс томилсон гишүүн хурлыг удирдана.
- 11.10 ТУЗ-ийн гишүүдийн дийлэнх олонх (*нийт гишүүдийн гуравны хоёр буюу түүнээс дээш нь*) оролцсоноор хурал хүчин төгөлдөр болох бөгөөд хуралд оролцож буй саналын эрхтэй гишүүдийн дийлэнх олонхийн (*нийт саналын гуравны хоёр буюу 66.6-аас доошгүй хувь*) саналаар шийдвэр хүчин төгөлдөр болно. Харин их хэмжээний хэлцэл хийх шийдвэрийг ТУЗ-ийн бүх гишүүд санал нэгтэй гаргана.
- 11.11 Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх асуудлыг шийдвэрлэж байгаа бол уг хэлцлээс ямар нэг хэлбэрээр орлого хүртэх боломжтой эсхүл өөрөө болон нэгдмэл сонирхолтой этгээд нь хэлцлийн нөгөө тал болж байгаа, эсхүл хэлцэлд зуучлагч, төлөөлөгчөөр оролцож байгаа ТУЗ-ийн гишүүн уг асуудлаар болон хэлцлийн зүйлийн үнийг тогтоох асуудлаар санал өгөх эрхгүй байна. Энэ тохиолдолд шийдвэрийг саналын эрхтэй гишүүдийн дийлэнх олонхийн саналаар гаргана. Гишүүдийн санал тэнцсэн тохиолдолд даргын саналаар асуудлыг шийдвэрлэнэ.
- 11.12 ТУЗ-ийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэж байгаа асуудлаар ТУЗ-ийн гишүүн бүр нэг саналын эрхтэй байна. ТУЗ-ийн аль нэг гишүүн нь эсрэг саналтай байгаа бол уг үндэслэлийг хурлын тэмдэглэлд заавал тэмдэглэсэн байна.



- 11.13 ТУЗ-ийн хуралд өөр гишүүнийг төлөөлөн санал өгөх, итгэмжлэлээр оролцохыг хориглоно.
- 11.14 ТУЗ-ийн хурлын тэмдэглэлд дараах асуудлыг заавал тусгасан байна:
- 11.14.1. Хурал хуралдсан газар, өдөр, цаг, хурлыг биечлэн, зайнаас, эсхүл эчнээ санал хураалт зэрэг ямар хэлбэрээр зохион байгуулсан тухай;
  - 11.14.2. Хурал даргалагчийн нэр;
  - 11.14.3. Хуралд оролцсон гишүүдийн нэрс, ирцийн хувь;
  - 11.14.4. Хурлаар хэлэлцсэн асуудлын жагсаалт;
  - 11.14.5. Асуудал бүрийг танилцуулсан, илтгэсэн хүний нэр
  - 11.14.6. Тухайн асуудлаар гарсан асуулт, хариу тайлбар, гишүүдийн гаргасан санал
  - 11.14.7. Санал хураалтын томъёолол, санал хураалтын дүн;
  - 11.14.8. Тухайн асуудлаар эсрэг саналтай байсан гишүүдийн нэр, эсрэг санал гаргасан үндэслэл;
  - 11.14.9. Гаргасан шийдвэр.
- 11.15 ТУЗ-ийн хурлын тэмдэглэлд хуралд оролцсон гишүүд гарын үсэг зурах бөгөөд тэмдэглэлийн үнэн зөвийг тухайн хурлын дарга хариуцна.
- 11.16 Төлөөлөн удирдах зөвлөлийн аль нэг гишүүн хурлын тэмдэглэлд гарын үсэг зурахаас татгалзсан бол энэ тухай бичгээр тайлбар гаргах бөгөөд уг тайлбарыг хурлын тэмдэглэлд хавсарган хадгална.
- 11.17 ТУЗ-ийн хурлын тэмдэглэлийг буруу хөтөлсөн нь уг хурлын шийдвэрийг хүчингүйд тооцох үндэслэл болохгүй.

#### **АРВАН ХОЁР. ТУЗ-ИЙН ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГАА**

- 12.1 ТУЗ нь жилийн ажлын төлөвлөгөө гарган ажиллана.
- 12.2 ТУЗ нь жилийн ажлын тайлангаа хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулна.
- 12.3 ТУЗ-ийн дэргэдэх Хороодын чиг үүрэгт хамаарах асуудлыг тухайн Хороо урьдчилан хэлэлцсэний үндсэн дээр ТУЗ-ийн хурлаар хэлэлцүүлнэ.
- 12.4 Компанийн бизнес төлөвлөгөө батлах, төсөл хэрэгжүүлэх, зээл авах, үндсэн хөрөнгө авах, данснаас хасах, хөрөнгө оруулалт хийх, компанийг тусгаарлах замаар өөрчлөн байгуулах зэрэг ихээхэн хэмжээний хөрөнгө зарцуулахтай холбогдсон асуудал, их хэмжээний хэлцэл, сонирхолын зөрчилтэй хэлцэл хийх асуудлыг хэлэлцэхэд ТУЗ-ийн болон түүний дэргэдэх Хорооны дарга шаардлагатай гэж үзвэл ажлын хэсэг байгуулан нарийвчлан судлуулж, санал, дүгнэлт гаргуулсны үндсэн дээр шийдвэр гаргана.
- 12.5 ТУЗ нь батлагдсан зардлын төсвийг зориулалтын дагуу зарцуулах бөгөөд тайланг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга гарган ТУЗ-ийн хуралд танилцуулна.
- 12.6 ТУЗ нь гишүүдийн ажил үүргийн хуваарийг батлан мөрдүүлэх, энэхүү журамд заасан хороодоос гадна тусгай чиг үүрэг бүхий хороог нэмж байгуулах замаар компанийн үйл ажиллагааг тогтворжуулах, хяналт тавих, шийдвэрийн биелэлтийг хангуулахад үр нөлөө бүхий арга хэлбэрийг ашиглаж ажиллана.
- 12.7 Энэхүү журмаар зохицуулагдаагүй аливаа асуудлыг тухай бүр нь ТУЗ-ийн хурлаар хэлэлцэж, хууль тогтоомж, компанийн дүрэм, журамд нийцүүлэн шийдвэрлэнэ.



## **АРВАН ГУРАВ. ТУЗ-ИЙН ГИШҮҮДИЙН ЦАЛИН, УРАМШУУЛАЛ**

- 13.1. ТУЗ-ийн гишүүдэд ТУЗ-ийн гишүүний үүрэгт ажил гүйцэтгэсний цалин, урамшуулал олгох, ТУЗ-ийн дэргэдэх хороодын гишүүний үүрэг гүйцэтгэсний нэмэгдэл, урамшуулал олгох эсэх асуудал, тэдгээрийн хэмжээ болон үйл ажиллагааны зардлын хэмжээг Хувьцаа эзэмшигчдийн хурлаас батална.
- 13.2. ТУЗ-ийн гишүүдэд олгох цалин урамшуулал болон үйл ажиллагааны зардлыг Компанийн жилийн зардалд тусгана.
- 13.3. ТУЗ-ийн гишүүний цалин, урамшууллыг олгох бөгөөд ТУЗ-ийн хурал, дэд хороодын хуралд биечлэн оролцсон ирц, оновчтой санал гаргасан байдлыг харгалзан олгоно.

## **АРВАН ДӨРӨВ. ТУЗ-ИЙН ГИШҮҮД, ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГАД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА**

- 14.1. ТУЗ-ийн гишүүд энэхүү журмыг зөрчсөн тохиолдолд энэ журамд заасан болон холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэх, зөрчилд холбогдох асуудлыг эрх бүхий байгууллагад шилжүүлэх болон цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар ТУЗ хэлэлцэж шийдвэрлэнэ.
- 14.2. ТУЗ дараах зөрчлийг гаргасан гишүүнд хариуцлага тооцох асуудлыг Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж, шийдвэрлүүлнэ. Үүнд:
  - 14.2.1. Компанийн эрх ашгийн эсрэг үйл ажиллагаа явуулсан;
  - 14.2.2. Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр нэг жилд нийт хурлын 1/3-ээс дээш удаа хуралд оролцоогүй;
  - 14.2.3. ТУЗ-ийн гишүүдийн олонхи ёс зүйн зөрчил гэж тодорхойлж буй зөрчлийг 1-ээс дээш удаа гаргасан;
  - 14.2.4. Компанийн үйл ажиллагаатай холбоотой мэдээ, тайлан, тоо баримтыг Компанийн тухай хууль болон бусад хууль тогтоомжид заасны дагуу нууцлах үүргээ зөрчсөн;
  - 14.2.5. Компанийн дүрэм, журам, холбогдох хууль тогтоомжийг зөрчсөн бусад зөрчил.
  - 14.2.6. Хувьцаа эзэмшигчдийн хурлаас нь энэхүү журмын 14-р зүйлийн 14.2 дахь хэсэгт заасан зөрчил гаргасан ТУЗ-ийн гишүүнд зөрчлийн шинж байдлыг харгалзан сануулах, эсхүл ТУЗ-ийн гишүүний цалин урамшууллыг 3 сараар 30 хувь хүртэлх хувиар бууруулах, хасах, эсхүл ТУЗ-ийн гишүүний бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох хариуцлага хүлээлгэнэ.
- 14.3. ТУЗ-ийн дарга дараах тохиолдолд ТУЗ-ийн нарийн бичгийн даргад түүний цалин, урамшууллын тодорхой хувийг хасах, үүрэгт ажлаас нь чөлөөлөх тухай саналаа ТУЗ-д оруулж шийдвэрлүүлнэ. Үүнд:
  - 14.3.1. ТУЗ-ийн гишүүдэд энэ журамд заасны дагуу мэдээлэл хүргээгүй, дутуу эсвэл хугацаа хожимдуулж хүрсэн асуудлаар ТУЗ-ийн даргад гишүүдээс гомдол ирсэн;
  - 14.3.2. Энэ журмаар хүлээсэн үүргээ гүйцэтгээгүй, буруу, дутуу гүйцэтгэсэн, хурлын тэмдэглэлд буруу мэдээлэл оруулсантай холбоотой ТУЗ-ийн хурлаар хэлэлцэх асуудал хойшлох, хурлын тогтоол хүчин төгөлдөр байдлаа алдсан;
  - 14.3.3. Компанийн тухай хууль болон энэ журамд заасан үүргээ удаа дараа, ноцтой зөрчсөн.



## АРВАН ТАВ. БУСАД

- 15.1. Энэхүү Журмын нэг, эсхүл хэд хэдэн заалтууд нь хүчингүй болох тохиолдолд энэ Журмын бусад зүйл, заалтууд нь хүчин төгөлдөр хэвээр мөрдөгдөнө.
- 15.2. ТУЗ нь хүчингүй болсон зүйл, заалтыг хууль тогтоомжид нийцүүлэн шинэчлэн найруулж, журамд өөрчлөлт оруулах асуудлыг ТУЗ-ийн хурлаар оруулж, шийдвэрлүүлнэ.
- 15.3. Энэхүү журамд ишэлсэн хууль тогтоомжийн аливаа зохицуулалтад өөрчлөлт орсноор холбогдох зүйл, хэсэг, заалтууд өөрчлөгдсөн нь журмын тухайн зохицуулалт хүчингүй болох үндэслэл болохгүй.
- 15.4. Энэхүү журмаар зохицуулаагүй аливаа харилцааг Монгол Улсын Компанийн тухай хууль, Иргэний хууль болон бусад холбогдох хууль тогтоомж болон Компанийн дүрэмд заасны дагуу зохицуулна.
- 15.5. Энэхүү журам нь ТУЗ-ийн хурлаар батлагдсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилнэ.

“ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ” ХК

~oOo~



ТУЗ-ийн ... оны .... тоот тогтоолоор батлагдсан

"ТУЗ-ийн үйл ажиллагааны журам"-ын

Хавсралт № 1

**“ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ” ХК-ИЙН  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
ХУРЛЫН ТОГТООЛ**

20...оны ... дугаар  
сарын ...-ний өдөр

Дугаар .....

Улаанбаатар хот

.....  
.....тухай  
Компанийн тухай хуулийн..... дугаар зүйл, Компанийн дүрмийн.....-д заасныг удирдлага болгон,  
.....  
..... үндэслэн,  
ТУЗ-ийн .....хорооны.....гэсэн дүгнэлт,  
гишүүн .....-ны.....гэсэн саналыг  
харгалзан үзэж, “ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 20...оны  
... дугаар сарын ...-ний өдрийн хурлаас ТОГТООХ нь:

1. ....

2. ....

Энэ тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Гүйцэтгэх захирал(....  
.....)-д үүрэг болгосугай

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
ДАРГА

.....



**“ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ” ХК-ИЙН  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
ЭЧНЭЭ САНАЛ ХУРААЛТЫН ТЭМДЭГЛЭЛ**

20.. оны ... дугаар  
сарын ...-ний өдөр

Дугаар .....

**“ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 20... оны ... дугаар сарын ...-ний өдрийн эчнээ санал хураалтаар:**

..... тухай асуудлыг хэлэлцэв.

ТУЗ-ийн дарга тухайн асуудлыг эчнээ санал хураалтаар хэлэлцүүлэхээр ... оны ... дугаар сарын ...-ны өдөр шийдвэрлэснийг үндэслэн гүйцэтгэх удирдлага (ТУЗ-ийн .....Хороо)-ын бэлтгэсэн хэлэлцэх асуудлын талаарх танилцуулга, ТУЗ-аас гарах тогтоолын төслийг ... оны ... дугаар сарын ...-ны өдөр гишүүдэд бичгээр (цахим шуудан) хүргүүлж, энэ тухай утсаар мэдэгдсэн байна.

ТУЗ-ийн дарга, нарийн бичгийн дарга, ..... нар бид ... оны ... дугаар сарын ...-ны өдөр ..... нарыг байлцуулан гишүүдээс бичгээр ирүүлсэн саналыг танилцвал:

1. Нийт гишүүдийн .... хувь буюу .... нь бичгээр, эсхүл цахим шуудангаар саналаа ирүүлсэн тул шийдвэр гаргах ирц хангалттай бүрдсэн байв.
2. Эчнээ саналаа ирүүлсэн буюу хуралд оролцсон гишүүдийн .... хувь нь уг асуудлыг дэмжсэн санал өгсөн байх тул **ШИЙДВЭРЛЭСЭН** нь:

"....."

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
ГИШҮҮД<sup>1</sup>**

.....

Тэмдэглэл хөтөлсөн:

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА**

.....

<sup>1</sup> ТУЗ-ийн эчнээ болон биечлэн оролцох хурлын тэмдэглэлийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга хөтөлж, уг тэмдэглэлийг хуралд оролцсон гишүүн бүр танилцаж, саналаа тусгуулан гарын үсэг зурна

ТУЗ-ийн ... оны .... тоот тогтоолоор батлагдсан  
"ТУЗ-ийн үйл ажиллагааны журам"-ын  
Хавсралт № 3

**“ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ” ХК-ИЙН  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
ХУРЛЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

20... оны ... дугаар .....  
сарын ...-ний өдөр Дугаар .....

**“ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ”** ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлыг 20... оны ... дугаар сарын ...-ний өдөр, .... цагаас .....(хурал болсон газрын хаяг) хийв. Хуралд Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга ..... , гишүүн ..... нар оролцов. Гишүүн ..... нар хуралд /бичгээр, утсаар/ санал өгсөн тул Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журмын 11.7 дахь заалтыг үндэслэн оролцсоноор тооцож, саналыг хавсаргав.

Хурлын ирц .... хувь. Гишүүн ..... нар ..... шалтгааны улмаас хуралд оролцоогүй болно. Гишүүн ..... нар тасалсан.

Хэлэлцсэн асуудал №1:

..... Танилцуулсан  
нь:

Асуулт:

Хариулт:.....

Гишүүдийн санал<sup>2</sup>:.....

Шийдвэрлэсэн нь:

Эсрэг саналтай байсан .....

Хэлэлцсэн асуудал №2:

..... Танилцуулсан  
нь:

Асуулт:

<sup>2</sup> Гишүүн бүрийн гаргасан саналыг аль болох хэлсэн шууд утгаар нь тэмдэглэлд оруулна. Хурлын явцыг дуу, дүрсээр бичиж баталгаажуулж заншвал маш сайн.



Хариулт:.....

Гишүүдийн санал:.....

Шийдвэрлэсэн нь:

.....

Эсрэг саналтай байсан .....

Тэмдэглэлтэй танилцсан:

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
ГИШҮҮД<sup>3</sup>

.....

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

.....

---

<sup>3</sup> Хуралд оролцсон бүх гишүүд гарын үсгээ зурна

ТУЗ-ийн ... оны .... тоот тогтоолоор батлагдсан  
"ТУЗ-ийн үйл ажиллагааны журам"-ын  
Хавсралт № 4

БАТЛАВ: ТУЗ-ийн Дарга

...../

/

**“ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ” ХК-ИЙН  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
ХУРЛЫН ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

20... оны ... дугаар

сарын ...-ний өдөр

Дугаар .....

.....

**“ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ” ХК-ийн ТУЗ-ийн 20...оны ... дугаар сарын ... өдрийн**  
... дугаар хурлаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөө:

Хурал 20... оны ... дугаар сарын ... -ны өдрийн ... цагт

..... –нд болно

| Д/д | Хэлэлцэх асуудал | Танилцуулах<br>албан<br>тушаалтан | Хуралд байлцах<br>(мэргэжилтэн,<br>шинжээч,<br>хөндлөнгийн<br>аудитор г.м.)<br>бусад тайлбар | Гарах шийдвэрийн<br>төсөл |
|-----|------------------|-----------------------------------|----------------------------------------------------------------------------------------------|---------------------------|
| 1   |                  |                                   |                                                                                              |                           |
| 2   |                  |                                   |                                                                                              |                           |
| 3   |                  |                                   |                                                                                              |                           |
| 4   |                  |                                   |                                                                                              |                           |

Хэлэлцэх асуудалтай танилцсан:

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

.....

Боловсруулсан:

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

.....



**“ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДЭРГЭДЭХ  
НЭР ДЭВШҮҮЛЭХ ХОРООНД**

**Нэр дэвшигчийн баталгаа<sup>4</sup>**

“Инновэйшн Инвестмент” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр нэр дэвшсэн ..... овогтой..... би дор дурдсан баталгаа гаргаж байна.

1. Би өөрөө, эсхүл нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран “Инновэйшн Инвестмент” ХК-ийн энгийн хувьцааны таваас дээш хувийг эзэмшдэггүй (КтХ-ийн 79.1.1) болно.
2. Би өөрөө, эсхүл нэгдмэл сонирхолтой этгээд нь “Инновэйшн Инвестмент” ХК болон тус компани оролцогч нь болж байгаа компанийн нэгдлийн бусад оролцогч хуулийн этгээдэд сүүлийн 3 жилийн хугацаанд ажил, албан тушаал эрхэлж байгаагүй, одоо ч ажил, албан тушаал эрхэлдэггүй (КтХ-ийн 79.1.2) болно.
3. Би төрийн үйлчилгээнийхээс бусад төрийн алба хашдаггүй (КтХ-ийн 79.1.3) болно. Тухайлбал, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, цэрэг, цагдаа, шүүх, прокурорын байгууллагад удирдах албан тушаал хашдаггүй (КтХ-ийн 84.3.1) болно.
4. Би “Инновэйшн Инвестмент” ХК-тай бизнесийн аливаа холбоогүй (КтХ-ийн 79.1.4) бөгөөд тус компанийн нэгдмэл сонирхолтой этгээдтэй ямар нэгэн хамааралгүй болно.
5. Компанийн засаглалын чиглэлээр сургалтанд хамрагдаж гэрчилгээ авсан (КтХ-ийн 75.8) болно.
6. Ял шийтгэл эдэлж байгаагүй (КтХ-ийн 84.3.2) болно.
7. Би албан татварын болон хугацаа хэтэрсэн их хэмжээний зээлийн өргүй (МХБ-ийн Үнэт цаасны бүртгэлийн журмын 11.1.4) болно. *(хэрэв өртэй бол татварын байцаагчийн акт, өрийн хэмжээ, хэрхэн төлж байгаа талаар, эсхүл зээлтэй бол ямар байгууллага, иргэнээс авсан хичнээн хэмжээний зээлийн үлдэгдэл байгаа, хугацаа хэтэрсэн эсэх, хуваарийн төлөгдөж байгаа эсэхийг үнэн зөвөөр бичнэ)*
8. Би мэргэжил, боловсрол, ажлын туршлагын хувьд “Инновэйшн Инвестмент” ХК-ийн ТУЗ-ийн гишүүнээр ажиллахад шаардагдах туршлагатай (МХБ-ийн Үнэт цаасны бүртгэлийн журмын 11.1.5) болохоо нотолж байна.
9. Би “Инновэйшн Инвестмент” ХК-ийн томоохон бизнесийн түншүүдтэй ямар нэгэн хамааралгүй болно.
10. Би Компанийн засаглалын кодексын 5.2.4-т заасан ТУЗ-ийн хараат бус гишүүнд тавигдах нэмэлт шаардлагуудыг хангаж байгаа болно.

**БАТАЛГАА ГАРГАСАН**  
**ТУЗ-ИЙН ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧ**

.....

20... оны ... дүгээр сарын ...

<sup>4</sup> Нэр дэвшүүлэх хороо буюу ТУЗ-ийн НБД Хараат бус гишүүнд нэр дэвшигчээс энэ баталгааг Нэр дэвшүүлэх хорооны хурлын дараа гаргуулж авна

ТУЗ-ийн .... оны .... тоот тогтоолоор батлагдсан  
"ТУЗ-ийн үйл ажиллагааны журам"-ын  
Хавсралт № 5-Үргэлжлэл  
"ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ" ХК-ийн ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
НЭР ДЭВШҮҮЛЭХ ДЭД ХОРООНД

**Нэр дэвшигчийн баталгаа<sup>5</sup>**

"Инновэйшн Инвестмент" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр нэр дэвшсэн  
..... овогтой..... би дор дурдсан баталгаа гаргаж байна.

1. Би төрийн үйлчилгээнийхээс бусад төрийн алба хашдаггүй (КтХ-ийн 79.1.3) болно.  
Тухайлбал, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, цэрэг, цагдаа, шүүх,  
прокурорын байгууллагад удирдах албан тушаал хашдаггүй (КтХ-ийн 84.3.1) болно.
2. Би Компанийн засаглалын чиглэлээр сургалтанд хамрагдаж гэрчилгээ авсан (КтХ-ийн  
75.8) болно.
3. Ял шийтгэл эдэлж байгаагүй ( КтХ-ийн 84.3.2) болно.
4. Би албан татварын болон хугацаа хэтэрсэн их хэмжээний зээлийн өргүй (МХБ-ийн Үнэт  
цаасны бүртгэлийн журмын 11.1.4) болно. *(МДСХ: хэрэв өртэй бол татварын  
байцаагчийн акт, өрийн хэмжээ, хэрхэн төлж байгаа талаар, эсхүл зээлтэй бол ямар  
байгууллага, иргэнээс авсан хичнээн хэмжээний зээлийн үлдэгдэл байгаа, хугацаа хэтэрсэн  
эсэх, хуваарийн төлөгдөж байгаа эсэхийг үнэн зөвөөр бичнэ)*
5. Би мэргэжил, боловсрол, ажлын туршлагын хувьд "Инновэйшн Инвестмент" ХК-ийн ТУЗ-  
ийн гишүүнээр ажиллахад шаардагдах туршлагатай (МХБ-ийн Үнэт цаасны бүртгэлийн  
журмын 11.1.5) болохоо нотолж байна.
6. Би "Инновэйшн Инвестмент" ХК, түүний нэгдмэл сонирхолтой этгээд, эсхүл томоохон  
бизнесийн түншүүдтэй дор дурдсан хамааралтай ("Инновэйшн Инвестмент" ХК-ийн  
дүрмийн 7.27.5- 7.27.7) болно:
  - a. (жишээ нь тус компанийн ... ширхэг буюу .. хувийн хувьцааг эзэмшдэг, эсхүл тус  
компанийн Гүйцэтгэх захирал, эсхүл тус компанийн УБ дахь борлуулалтыг  
хариуцсан менежер, эсхүл томоохон бэлтгэн нийлүүлэгч.... компанийн ГЗ, эсхүл  
тус компанийн зэргэлдээ компани болох .... ХК-ийн захирал, ня-бо, эсхүл ....  
хувийн хувьцаа эзэмшигч гэх мэтээр тодорхой бичнэ үү)

b. ....

БАТАЛГАА ГАРГАСАН  
ТУЗ-ИЙН ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧ

.....

20... оны ... дүгээр сарын ...

<sup>5</sup> Нэр дэвшүүлэх хороо буюу ТУЗ-ийн НБД нь ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр дэвшигчээс энэхүү баталгааг  
Нэр дэвшүүлэх хорооны хурлын дараа гаргуулж авна



**“Инновэйшн Инвестмент” ХК –ийн эрх бүхий албан тушаалтны нэгдмэл сонирхолтой  
этгээдийн мэдэгдэл<sup>6</sup>**

**“Инновэйшн Инвестмент” ХК –ын эрх бүхий албан тушаалтан (ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх  
захирал, энгийн хувьцааны 20-оос дээр хувийг эзэмшигч) ..... –ны нэгдмэл  
сонирхолтой этгээдийн жагсаалт**

Миний бие Компанийн тухай хуулийн 85.1-д заасныг үндэслэн өөрийн нэгдмэл сонирхолтой  
этгээдийн жагсаалтыг Компанийн тухай хуулийн 99.1.6-д зааснаар хүргүүлж байна. Үүнд (1-6  
дээр тухайн хүн/хүмүүсийн овог, нэр; 7 дээр хуулийн этгээдийн нэр болон 1-6-д дурдсан хүмүүсээс  
хэн нь хэдэн хувийг эзэмшдэгийг бичнэ):

1. Эхнэр/нөхөр:
2. Хүү/охин:
3. Ач, зээ:
4. Аав/ээж:
5. Ах, эгч, дүү:
6. Бусад төрөл, садангийн хүн:
7. Миний болон дээр дурдсан хүн/ хүмүүсийн хяналтын багц<sup>7</sup>ыг эзэмшдэг хуулийн этгээд:
  - а. Би “.....” ХК-ийн энгийн хувьцааны 50 хувийг эзэмшдэг
  - б. Эхнэр ..... “.....” ХК-ийн энгийн хувьцааг 100 хувь эзэмшдэг гм

Цаашид надтай нэгдмэл сонирхолтой дээрх хүмүүс, хуулийн этгээд болон түүний охин  
компани нь “Инновэйшн Инвестмент”-ХК-тай гэрээ, хэлцэл хийх тохиолдолд тухай бүр ТУЗ-д  
мэдээлж байх болно.

Гарын үсэг.....

Огноо:

<sup>6</sup> ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх захирал, энгийн хувьцааны 20-оос дээш хувийг эзэмшигч, санхүүгийн албаны дарга, ерөнхий нягтлан бодогч, ерөнхий мэргэжилтэн зэрэг компанийн албан ёсны шийдвэр гаргахад болон гэрээ хэлцэлд шууд буюу шууд бусаар оролцдог эрх бүхий албан тушаалд нэр дэвшигч, эсхүл тус албан тушаалд сонгогдсон буюу томилогдсон хүмүүсээс энэ мэдэгдлийг Нэр дэвшүүлэх хороо- ТУЗ-ийн НБД гаргуулж авна. НБД (эсхүл дотоод хяналт, комплаенс хариуцсан ажилтан) Компанийн нэгдмэл сонирхолтой этгээдийн жагсаалтыг хөтөлж, сонирхлын зөрчилтэй хэлцэл хийгдэх эсэхэд тогтмол хяналт тавьж ажиллана

<sup>7</sup> Тухайн компанийн энгийн хувьцааны 33.3-аас дээш хувийг хяналтын багц гэнэ

**“ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ” ХК -ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
 ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧИЙН  
 АНКЕТ**

1.Овог ..... 2.Нэр .....

2. Одоо хаана ямар ажилтай .....

3. Эрэгтэй                      эмэгтэй                      ( зурах)                      Зураг

4.Төрсөн .... он .. дүгээр сар ..-ны өдөр

5.Төрсөн аймаг/хот/....., Төрсөн газар .....

6.Одоогийн захиргаа ..... 7. Яс угсаа .....

8. Нийгмийн гарал ..... 9. Нийгмийн байдал .....

10. Ам бүлийн байдал ( зөвхөн ам бүлд байгаа хүмүүсийг бичнэ)

| № | Таны юу болох (эцэг,эх, ах дүү, хүүхэд, гэр бүл) | Овог нэр (хэний хэн) | Хаана ямар ажилтай | Нас |
|---|--------------------------------------------------|----------------------|--------------------|-----|
| 1 |                                                  |                      |                    |     |
| 2 |                                                  |                      |                    |     |

11. Төгссөн сургууль

| № | Хаана ямар сургууль, | Элссэн,төгссөн он | Эзэмшсэн мэргэжил | Диплом № |
|---|----------------------|-------------------|-------------------|----------|
| 1 |                      |                   |                   |          |
| 2 |                      |                   |                   |          |
| 3 |                      |                   |                   |          |

12. Ажилласан байдал

| № | Хаана ямар байгууллага, | Орсон, гарсан он | Албан тушаал |  |
|---|-------------------------|------------------|--------------|--|
|   |                         |                  |              |  |



|  |  |  |  |  |
|--|--|--|--|--|
|  |  |  |  |  |
|  |  |  |  |  |
|  |  |  |  |  |
|  |  |  |  |  |
|  |  |  |  |  |

13. ТУЗ-ийн гишүүнээр ажилласан байдал

| № | Хаана ямар компанид | Сонгогдсон,<br>гарсан он | Ердийн болон хараат<br>бус гишүүн алин болох | Тайлбар |
|---|---------------------|--------------------------|----------------------------------------------|---------|
|   |                     |                          |                                              |         |
|   |                     |                          |                                              |         |
|   |                     |                          |                                              |         |
|   |                     |                          |                                              |         |
|   |                     |                          |                                              |         |
|   |                     |                          |                                              |         |

14. Мэргэжил дээшлүүлсэн байдал

| № | Хаана ямар байгууллага, | Хэдийд ямар хугацаатай | Мэргэжил дээшлүүлсэн чиглэл |
|---|-------------------------|------------------------|-----------------------------|
|   |                         |                        |                             |
|   |                         |                        |                             |
|   |                         |                        |                             |
|   |                         |                        |                             |

15. Ур чадвар:

|                                                 | Сайн | Дунд | Анхан шатны |
|-------------------------------------------------|------|------|-------------|
| Компьютерийн өргөн<br>хэрэглээний<br>програмууд |      |      |             |
| Гадаад хэл:                                     |      |      |             |
| 1                                               |      |      |             |
| 2                                               |      |      |             |
| 3                                               |      |      |             |
| 4                                               |      |      |             |
| Урлаг:                                          |      |      |             |
| 1.                                              |      |      |             |
| 2.                                              |      |      |             |
| 3.                                              |      |      |             |
| 4.                                              |      |      |             |
| Спорт:                                          |      |      |             |
| 1.                                              |      |      |             |
| 2.                                              |      |      |             |
| 3.                                              |      |      |             |

|       |  |  |  |
|-------|--|--|--|
| 4.    |  |  |  |
| 5.    |  |  |  |
| Бусад |  |  |  |
|       |  |  |  |

16. Компанийн хувьцааг өөрөө болон нэгдмэл сонирхолтой этгээд нь эзэмшдэг эсэх, эзэмшдэг бол ямар төрлийн хэдэн ширхэг хувьцаа

17. Компанитай бизнесийн аливаа хамааралтай эсэх, хамааралтай бол ямар

18. Компанид болон компани харьяалагддаг нэгдлийн аль нэг оролцогч компанид өөрөө болон нэгдмэл сонирхолтой этгээд нь эрх бүхий албан тушаал хашдаг эсэх, хашдаг бол:

18.1. Ямар компанид .....

18.2. Хэн.....

18.3. Ямар албан тушаал хашдаг.....

18.4. Нэгдмэл сонирхолтой этгээд бол Тантай ямар хамааралтай.....

19. Гавьяа, шагнал: .....

20. Өөрийн иргэний үнэмлэх, регистрийн дугаар, оршин суугаа хаяг, ажлын ба гэрийн утасны дугаар: .....

21. Онц яаралтай тохиолдолд танд мэдээ дамжуулах , холбоо барих хоёр хүний овог нэр, гэрийн хаяг, утасны дугаар (таны юу болох)

.....  
 .....

АНКЕТАА ҮНЭН ЗӨВ БИЧСЭН.....

ОГНОО:





**INNOVATION**  
Investment

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг 1-р хороо  
Элчингийн гудамж Шүрэн оффис 6 тоот  
Утас: 976-7610-2211, Имэйл: info@qpay.mn

**“ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ” ХК  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2024 оны 5 дугаар  
сарын 27-ны өдөр

№ 05/03

Улаанбаатар  
хот

**Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журмын шинэчилсэн найруулгыг батлах  
тухай**

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.13 дахь заалт, 80 дугаар зүйлийн 80.2 дахь хэсэг, “Инновэйшн Инвестмент” ХК (цаашид “**Компани**” гэх)-ийн дүрэм, Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 145 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Компанийн засаглалын кодексн шинэчилсэн найруулга”-ын холбогдох хэсэг болон Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 02/17 тоот тогтоолын хоёрдугаар хавсралтаар сайшаан батлагдсан “Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ын холбогдох хэсгийг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Компанийн “Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ын шинэчисэн найруулгыг энэхүү тогтоолын Хавсралт №1-ийн дагуу баталсугай.
2. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан “Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ын шинэчисэн найруулгыг батлагдсан өдрөөс нь эхлэн хүчин төгөлдөрт тооцож, үйл ажиллагаандаа дагаж мөрдөж ажиллахыг нийт Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд, Гүйцэтгэх захирал болон бусад ажилтан албан хаагчид үүрэг болгосугай.
3. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан 2020 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар батлагдсан “Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ыг хүчингүй болсонд тооцсугай.
4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аудитын хороонд үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



А.БАТТАМИР

